



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/98

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.10, 42 дугаар зүйлийн 42.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй малчин эцэг эхчүүдийн бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх замаар хүүхдийнхээ сурч хөгжих болон сайн сайхан байдлыг дэмжих, чадавхыг сайжруулах нь” төслийг суманд үр дүнтэй зохион байгуулах, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: Г.Дуламдорж (Насан туршийн боловсролын арга зүйч)

Гишүүд: Н.Долгормаа (Халамж хариуцсан нийгмийн ажилтан)

Багийн Засаг дарга нар

2. Төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл судалгааг цаг хугацаанд нь гаргаж, үр дүнтэй хэрэгжүүлж, тайлан мэдээг холбогдох газарт хүргүүлж, Засаг даргад танилцуулахыг Засаг даргын орлогч (Н.Орхонтуул)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

